



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/265

Арвайхээр

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд “Аймгийн отрын бүс нутаг”-ийн хил заагийг нарийвчлан шинэчлэн тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардал, явах маршрутыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд “Аймгийн отрын бүс нутаг”-ийн хил заагийг нарийвчлан шинэчлэн тогтоох ажилд дэмжлэг үзүүлэн, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт, дээрх ажлыг аймгийн хэмжээнд сайтар зохион байгуулж үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг (С.Цэдэнбалжир)-т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100568

Аймгийн Засаг даргын 2021 оны...<sup>06</sup>  
дугаар сарын .<sup>04</sup>.-ны өдрийн <sup>А/265</sup>...дүгээр  
захирамжийн нэгдүгээр хавсралт



**“АЙМГИЙН ОТРЫН БҮС НУТАГ”-ИЙН ХИЛ ЗААГИЙГ  
НАРИЙВЧЛАН ШИНЭЧЛЭН ТОГТООХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн дарга: С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс,  
хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Б.Цэнгэл -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж  
ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

Н.Дулам –аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн ахлах мэргэжилтэн


С.Аравзайлхам –аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын  
харилцаа, барилга, хот байгуулалтын газрын  
мэргэжилтэн

Холбогдох сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Т.Эрдэнэбаяр -аймгийн Засаг даргын дэргэдэх  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны...*06*.  
дугаар сарын *04*..-ны өдрийн *М/Б*..дүгээр  
захирамжийн хоёрдугаар хавсралт



**“АЙМГИЙН ОТРЫН БҮС НУТАГ”-ИЙН ХИЛ ЗААГИЙГ  
НАРИЙВЧЛАН ШИНЭЧЛЭН ТОГТООХОД ШААРДАГДАХ  
ЗАРДАЛ, ЯВАХ МАРШРУТ**

д/д	Явах маршрут	Сум хооронд явах км	Отрын бүс нутгаар явах км	Нийт явах км	Шатахуун литр	Мөнгөн дүн төгрөг
1	Арвайхээр-Бүрд	140	110	250	66	99000
2	Есөнзүйл	50	80	130	43	64500
3	Өлзийт	60	50	110	40	60000
4	Баян-Өндөр	55	90	145	53	79500
5	Сант	50	200	250	72	108000
6	Баянгол	50	60	110	56	84000
7	Төгрөг	50	160	210	58	87000
8	Гучин-Ус	55	180	235	61	91500
9	Богд	110	210	320	86	129000
10	Баруунбаян- Улаан	120	210	330	80	120000
11	Нарийнтээл	160	170	330	80	120000
12	Хайрхандулаан	70	100	170	58	87000
13	Тарагт	65	110	175	65	97500
14	Уянга	35	130	165	56	84000
15	Бат-Өлзий	50	140	190	55	82500
16	Хужирт	55	90	145	53	79500
17	Арвайхээр	80		80	18	27000
		1290	3710	5000	1000	1500000